



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Барилга акталж, нийслэлийн өмчийн  
бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 481 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Баянзүрх дүүрэг дэх 297 дугаар цэцэрлэгийн барилга баригдсантай холбогдуулан “Өнөр бүл хүүхдийн төв”-ийн баланст бүртгэлтэй, 5,145,043.00 (таван сая нэг зуун дөчин таван мянга дөчин гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад дурдсан ногоон зоорийн байрыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.


ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110101117

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн  
119 дугаар тогтоолын хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл \2024.06.30\	Үлдэгдэл өртөг	Акталж данснаас хасах үндэслэл
1	Өнөр бүл хүүхдийн төвийн Ногоон зоорийн байр	1995	м2	45	5,145,043.00	5,145,043.00		Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Баянзүрх дүүргийн 297 дугаар цэцэрлэгийн шинэ барилга баригдсан
<b>НИЙТ ДҮН</b>					<b>5,145,043.00</b>	<b>5,145,043.00</b>		